



ҮАГ-ЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

ЭРСДЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хушаат сумын төр, төсвийн байгууллагуудын
санхүүгийн зарим үйл ажиллагаа

Ерөнхий дүгнэлт:

Хушаат сумын төрийн сангийн хяналтын үйл ажиллагаа хангалтгүйгээс зохих зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд болон эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулах, тогтмол зардлын төлбөрийг бэлнээр гарган зориулалт бусаар зарцуулах, гэрээний дүнгээс илүү санхүүжилт олгох зэрэг зөрчлүүд нийтлэг байдлаар оршиж байна

Сүхбаатар сум 2015 он

Тайланг бэлтгэсэн:

**Сэлэнгэ аймгийн
Аудитын газар**

Дарга, Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа
Аудитын менежер
Б.Батмөнх
Аудитор Ц.Отгонбаяр
Шинжээч С.Баасансүрэн
Э.Эрдэнэзул
А.Дашбат

2015 оны 09 дүгээр сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70363036 дугаарын
утсаар харилцана уу

ХАЯГ:

Сэлэнгэ аймаг
Сүхбаатар хот
Аймгийн ЗДТГ-ын
өргөтгөлийн 2-р давхар

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4

Бүлэг 1.Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу
зарцуулж байна уу?

Бүлэг 2. Хөрөнгийн худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэл

Бүлэг 3.Татварын орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Дүгнэлт.....9

Зөвлөмж.....10

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ААГ	Аймгийн Аудитын газар
УЗ	Удирдлагын зөвлөл
ЭА	Эрсдэлийн аудит
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчидийн хурал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудитын нэр:

“Сэлэнгэ аймгийн Хушаат сумын Төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн зарим үйл ажиллагаа”

2. Аудитын код:

СЭЛ-2015/04-ЭА

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг МУ-ын Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

4. Аудитын зорилт:

Хушаат сумын төр, төсвийн байгууллагуудын 2013, 2014 оны санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зарим эрсдэлтэй асуудлыг сонгон шалгаж, дүгнэлт гарган, санал зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад эрсдэлийн аудитын зорилт чиглэгдсэн болно. Эрсдэлийн аудитыг 3 дэд асуудлаар шалган гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байна уу?
2. Хөрөнгийн худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэл
3. Татварын орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

5. Аудитын хамрах хүрээ:

Хушаат сумын төр, төсвийн байгууллагуудын 2013, 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхийн тулд тус байгууллагуудын санхүүгийн тайлан баланс, НББ-ийн анхан шатны баримт болон бусад баримт материал, мэдээллийн эх сурвалжуудыг хамруулав.

6. Аудитын арга зүй:

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн шалгалтын журам, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын гарын авлага, аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Тус сумын төсөвт байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч, эд хариуцагч нартай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, нотлох зүйлийг ашиглан судалгаа, шинжилгээ хийх, давтан шалгах зэрэг арга зүйг ашиглалаа.

Аудитын дүн, дүгнэлтэнд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

7. Үндсэн мэдээлэл

Хушаат сумын төсвийн орлогод 2013 онд төлөвлөгөөгөөр 30479,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 28502,5 мянган төгрөг, 2014 онд 47111,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 44881,5 мянган төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

2014 онд сумын хэмжээгээр урсгал санхүүжилт 100 хувь олгогдсон бөгөөд орон нутгийн төсөвт байгууллагууд 337236,4 мянган төгрөгийн, тусгай шилжүүлгийн байгууллагууд 769951,7 мянган төгрөгийн зарлага гарган ажиллажээ.

Орон нутгийн байгууллагуудын урсгал санхүүжилтийн 52,8 хувийг цалин хөлс, 6,0 хувийг тогтмол зардалд, 37,9 хувийг бараа үйлчилгээний зардалд, 3,3 хувийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулсан байна.

Аймгийн ОНХС-аас тус сумын ОНХС-д 2013 онд 221463,0 мянган төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн боловч 19270,1 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, 202192,9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр, 2014 онд 297200,0 мянган төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн ч 116600,0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, 180600,0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр тус тус тайлагнасан байна.

Сум хөгжүүлэх санд 2013 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 100000,0 мянган төгрөгийн санхүүжилт, зээлийн эргэн төлөлтөөс 13000,0 мянган төгрөгийн, нийт 113000,0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 113000,0 мянган төгрөгийн зээл олгосон бол 2014 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 8000,0 мянган төгрөгийн санхүүжилт, зээлийн эргэн төлөлтөөс 20000,0 мянган төгрөгийн нийт 28000,0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 27000,0 мянган төгрөгийн зээл олгожээ.

БҮЛЭГ 1.Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байна уу?

1.1. Цалин НДШ-ийн зардлыг бодитой төлөвлөж зарцуулсан эсэх

Хушаат сумын төсөвт байгууллагуудын цалин, НДШ-ийн зардлын төлөвлөлтийг гүйцэтгэлтэй нь тулган шалгах гэсэн боловч тайлант онуудын төсвийн төслийг архивлан хадгалаагүй байлаа. Иймээс цаашид төсвийн төслийг албан ёсоор баталгаажуулж, баталгаажсан нэг хувийг санхүүгийн баримтанд хавсаргаж байх шаардлагатай байна.

2013, 2014 оны цалин, НДШ-ийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-1 /мян.төг/

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2013 ОН		2014 ОН	
		төсөв	гүйцэтгэл	төсөв	гүйцэтгэл
ЗДТГ	цалин	114219,5	114219,5	130253,2	130183,2
	НДШ	12641,8	12641,8	14562,7	14562,7
Баг	цалин	15019,6	15019,6	15590,6	15590,6
	НДШ	1652,2	1652,2	1942,0	1942,0
ИТХ	цалин	22774,6	2277 4,6	26291,1	26228,9
	НДШ	2505,2	2505,2	2983,1	2688,2
ЭМТ	цалин	101401,4	101401,4	110593,0	109499,8

	НДШ	12215,9	12215,9	12165,2	12111,0
Сургууль	цалин	207308,4	207308,4	238313,9	238313,9
	НДШ	20019,8	20019,8	24937,8	24937,8
Цэцэрлэг	цалин	89009,2	87267,2	105726,4	105719,1
	НДШ	9992,8	9194,9	12524,8	12524,8
Соёлын төв	цалин	42021,0	42020,9	43204,6	43204,6
	НДШ	4677,5	4562,6	4758,4	4758,4

Тус сумын төсөвт байгууллагуудын цалингийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримт, цагийн бүртгэл, холбогдох тушаал шийдвэртэй нь тулган баталгаажуулахад тушаал шийдвэргүй нэмэгдэл цалин олгосон, ур чадварын нэмэгдлийг хувь хэмжээнээс илүү олгосон, цалингийн урьдчилгааг дутуу суутгасан, амралтын цалинг давхардуулан олгосон зэрэг дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

МУ-ын Төсвийн тухай хуулийн 6.4.1¹, 16.5.5², ЗГ-ын 2014 оны 147 дугаар тогтоолыг зөрчиж :

- ЭМТ нь 2013 оны 9-р сард сувилагч С.Болормаагийн амралттай байх хугацааны цалинг 3 хувааж Г.Оюунтуяа, Ч.Надмид, Г.Батцэцэг нарт нийт 417,8 мянган төгрөг, 2014 оны 4-р сард Г.Оюунтуяад 100,0 мянган төгрөг, 6 сард С.Болормаад 100,0 мянган төгрөг, Г.Батцэцэгт 120,0 мянган төгрөгийн илүү цалинг тус тус тушаал шийдвэргүйгээр олгосон,
- Их эмч А.Сарантуяа нь 2014 оны 5 сараас эрхлэгч Ц.Батзаяагийн ажлыг түр хавсран гүйцэтгэсэн бөгөөд ажилласан 4 сарын хугацаанд ажил хавсарсны 40%-ийн нэмэгдлийг эрхлэгчийн цалингийн шатлалаас тооцож 475,2 мянган төгрөг илүү олгосон,
- 2014 оны 5-р сард сувилагчийн өдрийг тохиолдуулан эрхлэгчийн 13 тоот тушаалаар 4 сувилагчид тус бүр 100,0 мянган төгрөг, нийт 400,0 мянган төгрөгийн урамшууллыг ЗГ-ын 2012 оны 150 дугаар тогтоолоор олгодог улирлын урамшуулалттай давхардуулан олгосон,
- ЕБС нь 2014 оны 6-р сард сургалтын менежер Г.Оюунцогзолмаагийн цалин дээр 290,0 мянган төгрөгийн тодорхойгүй нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр олгосон,
- Цэцэрлэг нь 2013 оны 12-р сард галч Л.Туваанжавт сантехникчийн, багш О.Бямбацэцэгт арга зүйчийн, багш Б.Баясгаланд архив, бичиг хэргийн ажлуудыг хавсран ажиллуулсаны 40 хувийн нэмэгдэлд 2703,9 мянган төгрөгийг тушаал шийдвэргүйгээр олгосон байлаа. Аудитын явцад эрхлэгч Ц.Алимцэцэг нь галч Л.Туваанжавыг 2013 оны 01-р сарын 10-ны өдрөөс сантехникийн, багш О.Бямбацэцэг, багш Б.Баясгалан нарыг арга зүйч, архив бичиг хэргийн ажлыг 08-р сарын 01-ний өдрөөс хавсран ажиллуулж 40 хувийн нэмэгдэл цалин олгохоор тушаал гаргасан хэмээн 1 хувийг үзүүлсэн боловч Төрийн сангаар хянагдаагүй, цалингийн баримтанд хавсаргаагүй байв.

¹Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

²Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

МУ-ын Боловсрол, Соёл шинжлэх ухааны сайд, Нийгмийн Хамгаалал хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 362/112/183 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийн 4³ дахь заалтыг зөрчиж:

- ЕБС-ийн захирал Л.Оюунд 5 хувиар буюу 289,0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг илүү олгосон,

МУ-ын Төсвийн тухай хуулийн 41.2.3⁴, НББ-ийн тухай хуулийн 7.1⁵, 9.1⁶ дахь заалтыг зөрчиж:

- 2-р багийн Засаг дарга Г.Батдоржид цалингийн урьдчилгаа олгоод буцаан суутгаагүй, санхүүгийн тайланд авлага үүсгээгүй 60,0 мянган төгрөг,
- ЕБС нь ажилтнуудад олгосон цалингийн урьдчилгаанаас 500,0 мянган төгрөгийг дутуу суутгаад, санхүүгийн тайланд авлага үүсгээгүй,
- ЕБС-ийн нягтлан бодогч Б.Номин нь 2014 онд ээлжийн амралтын 433,6 мянган төгрөгийн цалинг давхардуулан авсан байна.

Цаашид төсвийн төслийг албан ёсоор баталгаажуулж хувийг санхүүгийн баримтад хавсаргах, ажилтнуудад олгосон цалингийн урьдчилгааг тогтмол суутгаж авлага, өглөг үүсгэхгүй байх, цалингийн нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох, цалингийн зардалд тавих хяналтыг сайжруулан батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах шаардлагатай байна.

1.2. Тогтмол зардлыг бодитой төлөвлөж зарцуулсан эсэх

Хушаат сумын төсвийн байгууллагууд нь бага оврын зуухаар галладаг бөгөөд 2013 оны эхний хагас жилд Бурхантын Илч ХХК, сүүлийн хагас жилд СООБ ХХК-иудтай гэрээ хийн нүүрс худалдан авсан байна. Харин 2014 онд СООБ болон ОБООНО ХХК-иудаас нүүрс худалдан авчээ.

Төвлөрсөн шугаманд холбогдоогүй тул цэвэр бохир усны зардал гардаггүй бөгөөд ЭМТ, цэцэрлэг, соёлын төвд бага хэмжээний зардал батлагдсан байна. Гэрэл цахилгааны зардлын хувьд Дархан Сэлэнгийн ЦТС ХХК-тай гэрээ байгуулан ажилласан байна.

Төсөвт байгууллагуудын тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрөл тус бүрээр нь хүснэгтээр харуулбал:

³Ур чадварын нэмэгдлийн хэмжээг ур чадварын шалгуур үзүүлэлтийн хангалтын хувь, түвшнээс хамааруулан тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 10-30 хувь байхаар тогтооно.

⁴төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах

⁵Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно

⁶Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана

Байгууллагын нэр	Зардлын төрөл	2013 он		2014 он	
		төсөв	гүйцэтгэл	төсөв	гүйцэтгэл
ЗДТГ	Гэрэл цахилгаан	1280,4	1280,4	1391,4	1457,2
	Түлш халаалт	19354,9	19354,9	14877,8	14811,9
БЗД	Гэрэл цахилгаан	0	0	600,0	600,0
	Түлш халаалт	0	0	8746,3	8746,3
ЭМТ	Гэрэл цахилгаан	1516,5	1588,9	1824,0	1824,4
	Түлш халаалт	6981,3	7346,0	14065,6	14065,6
	Цэвэр бохир ус	675,0	237,9	171,5	171,5
Сургууль	Гэрэл цахилгаан	3492,4	3557,8	4115,7	4115,7
	Түлш халаалт	27494,7	27494,2	24857,8	24857,8
	Цэвэр бохир ус	196,2	130,8	0	0
Цэцэрлэг	Гэрэл цахилгаан	2362,4	2709,6	3512,9	3512,9
	Түлш халаалт	9531,4	9183,8	9434,8	9434,8
	Цэвэр бохир ус	0	0	86,5	86,5
Соёлын төв	Гэрэл цахилгаан	891,2	891,2	2055,7	2055,7
	Түлш халаалт	18397,3	18397,3	17764,4	17764,4
	Цэвэр бохир ус	144,0	144,0	96,0	96,0

Тогтмол зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад халаалт, цахилгааны зардлыг бэлнээр гарган бусад зардалд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулах, тогтмол зардлыг хооронд нь гүйлгэн зарцуулаад гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй зэрэг дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

МУ-ын Төсвийн тухай хуулийн 41.2.3, НББ-ийн тухай хуулийн 7.1, Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 5.4⁷ дэх заалтуудыг зөрчиж:

- ЭМТ нь гэрэл цахилгааны зардлаас халаалтын зардалд 1000,0 мянган төгрөгийг, халаалтын зардлаас гэрэл цахилгааны зардалд 317,0 мянган төгрөгийг,
- Цэцэрлэг нь түлш халаалтын зардлаас гэрэл цахилгааны зардалд 2014 онд 1127,0 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.5⁸, НББ-ийн тухай хуулийн 7.1, Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт

⁷Төсвийн байгууллага нь зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллын дагуу зардал гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн өр, төлбөр үүсгэхгүйгээр хөтөлбөр арга хэмжээний зорилтыг бүрэн хангахаар төсвийг зарцуулна.

⁸Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

хийх журам”-ын 5.2⁹, 5.3¹⁰ дахь заалтууд болон Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ыг зөрчиж:

- ЗДТГ нь 2013 онд халаалтын зардлыг бэлнээр гарган нормын хувцас худалдан авахад 200,0 мянган төгрөг, автомашины сэлбэг худалдан авахад 80,0 мянган төгрөг, сантехникийн засварт 100,0 мянган төгрөгийг,
- Сургууль нь цахилгааны зардлаас¹¹ засварын зардалд 2013 онд 875,3 мянган төгрөгийг, 2014 онд 456,8 мянган төгрөгийг,
- Цэцэрлэг нь 2013 онд түлш халаалтын¹² зардлыг бэлнээр гарган сантехникийн материал худалдан авахад 1114,4 мянган төгрөгийг, үнс ачуулсан тээврийн хөлсөнд 71,5 мянган төгрөгийг, 2014 онд гэрэл цахилгааны зардлаас цахилгааны засварт 258,9 мянган төгрөгийг, цэвэр бохир усны зардлаас цэвэрлэгээний материалд 86,5 мянган төгрөгийг,
- Соёлын төв нь гэрэл цахилгааны зардлаас бараа материал худалдан авахад 893,2 мянган төгрөгийг тус тус холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

МУ-ын НББ-ийн тухай хуулийн 9.1, Санхүү, Эдийн засгийн сайдын 2002 оны 191-р тушаалын 6.3¹³ дахь заалтыг зөрчиж:

- ЭМТ нь 2013 онд 5403,5 мянган төгрөгийн, 2014 онд 9,106.0 мянган төгрөгийн нүүрс худалдан авч, өдөр болон сард хэрэглэх нүүрсний норматив тогтоолгүйгээр худалдан авсан дүнгээр зарлагадаж хяналтгүйгээр зарцуулсан байна. Мөн 2014 онд өмнөх онтой харьцуулахад талбайн хэмжээ өөрчлөгдөөгүй байхад 2 дахин их нүүрс зарцуулсан нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ЗГ-ын 2014 оны 147-р тогтоолын 3.9¹⁴ дахь заалтуудыг зөрчсөн байна.

⁹Төсвийн байгууллага зардлын бүлэг хоорондын зохицуулалтын хүсэлтийг ТЗБ №1 маягаар бэлтгэн, энэ журмын 4-т заасан шаардлагыг хангасан материалын хамт харьяа төрийн санд хүргүүлнэ.

¹⁰Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь төсвийн байгууллагаас ирүүлсэн 10 сая төгрөг хүртэлх зохицуулалт хийх хүсэлтийг судлан, зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд зохицуулалтыг хийж, бүртгэн баталгаажуулна

¹¹гэрэл цахилгааны зардалд үйлчлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээ болон цахилгаан эрчим хүчийг хэмжиж, хэмжих тоолуурын заалтын дагуу байгууллагын хэрэгцээнд ашигласан цахилгаан эрчим хүчний төлбөрийг харуулна

¹² Уурын болон дулааны халаалтад холбогдсон байгууллага үйлчлэгч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлөх дулааны эрчим хүч болон халуун усны төлбөр, мөн түүнчлэн ердийн халаалтын зууханд хэрэглэх аргал, түлээ, нүүрс, мод зэрэг түлшинд гарсан зардлыг харуулна. Түлш бэлтгэхтэй холбоотойгоор гарах тээвэр шатахууны зардлыг энэ ангилалд бүртгэхгүй, тээвэр, шатахууны зардалд бүртгэнэ.

¹³Бараа материалын бүртгэл

¹⁴ Орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөлд нийцүүлж спорт заал, соёлын төв зэрэг төсөвт байгууллагын барилга байгууламжийг төвлөрсөн дулааны системд холбох, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан халаалт зэрэг бусад үр ашигтай арга, технологи нэвтрүүлэх замаар түлш, халаалтын зардал хэмнэх, цаашид ийм төрлийн зардлыг тогтмол түвшингээр төсөвлөх, улмаар үе шаттай бууруулах

Иймээс цаашид тогтмол зардлын гүйлгээг бэлнээр гүйцэтгэхгүй байх, зайлшгүй шаардлагаар зардлын бүлэг хооронд болон эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох дээд байгууллагаас журмын дагуу зөвшөөрөл авч, гүйцэтгэлийг бодитоор тайлагнах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, норм нормативыг албан ёсоор баталгаажуулж, зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

1.3. Эм, хоол, үдийн цай болон бусад зардлыг бодитой төлөвлөж зарцуулсан эсэх

Тус сумын төсөвт байгууллагуудын 2013, 2014 оны эм, хоолны зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3 /мян.төг/

Байгууллагын нэр	Зардлын төрөл	2013 он		2014 он	
		төсөв	гүйцэтгэл	төсөв	гүйцэтгэл
ЭМТ	хоол	3108,9	3108,9	3976,2	3976,2
	эм	7609,1	7609,1	8688,9	8688,9
Сургууль	хоол	15440,2	15439,8	16161,6	16161,6
	эм	138,9	138,9	149,8	149,8
Цэцэрлэг	хоол	22839,8	22839,8	24403,5	24403,5
	эм	27,3	27,3	54,7	54,7

Аудитын явцад эм, хоолны зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай нь тулган баталгаажуулахад эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулаад гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй, 1 хүүхдэд ноогдох хоолны нормативт зардлыг хэтрүүлэн олгосон зэрэг дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

МУ-ын Төсвийн тухай хуулийн 41.2.3, НББ-ийн тухай хуулийн 7.1, Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 5.4¹⁵ дэх заалтуудыг зөрчиж:

- ❖ ЭМТ нь хоолны зардлаас эмийн зардалд 1,065.5 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй
- ❖ Цэцэрлэг нь эмийн зардлаас 2013 онд 27,3 мянган төгрөгийн, 2014 онд 54,7 мянган төгрөгийн ариутгалын бодис худалдан авсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

МУ-ын ЗГ-ын 2012 оны “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” 106 дугаар тогтоолын 2¹⁶ дахь заалтыг зөрчиж:

¹⁵Төсвийн байгууллага нь зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллын дагуу зардал гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн өр, төлбөр үүсгэхгүйгээр хөтөлбөр арга хэмжээний зорилтыг бүрэн хангахаар төсвийг зарцуулна.

¹⁶Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1650 төгрөгөөр, 24 цагаар ажилладаг цэцэрлэг, сувиллын болон тусгай цэцэрлэгт 2400 төгрөгөөр тус тус тогтоосуугай

- Цэцэрлэг нь нэг хүүхдэд ноогдох хоолны нормативт зардлыг 2013 онд 369,2 мянган төгрөгөөр, 2014 онд 57,8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Бусад зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх:

МУ-ын Сангийн сайдын 2011 оны “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 132 тоот тушаалыг зөрчсөн, томилолтын зардлын гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ЗДТГ-ын нягтлан бодогч Б.Цогбаярт төрийн захиргааны албан хаагчийн тарифаар тооцож, зочид буудлын баримтгүйгээр 90,0 мянган төгрөгийн томилолтын зардал илүү олгосон,
- ЕБС нь 48,0 мянган төгрөгийн томилолтын зардлыг томилолтын хуудасгүйгээр олгосон байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 7.1, Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5.2 болон “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 5.4 дахь заалтуудыг зөрчиж:

- ЗДТГ нь 2014 онд томилолтын зардлаас цахилгааны зардалд 36,6 мянган төгрөгийг, шуудан холбооны зардлаас бичиг хэргийн зардалд 115,0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулаад гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 15¹⁷ дахь заалтыг зөрчиж, сумын Засаг даргын 2014 оны 1-р сарын 27-ны А/10 тоот захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөнөөс ЭМТ-д тоног төхөөрөмж худалдан авахад 1360.0 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ.

Цаашид зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох байгууллагаас журмын дагуу зөвшөөрөл авч гүйцэтгэлийг бодитоор тайлагнах, 1 хүүхдэд ноогдох хоолны нормативт зардлыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

1.4. Тусгай сангийн төлөвлөлт, зарцуулалт

ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт:

Хушаат сумын ОНХС-д 2013 онд 221463,0 мянган төгрөг батлагдснаас 202192,9 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ОНХС-аас хуваарилж, олгосон байна. Тайлант онд 11 төрлийн 221463,0 мянган төгрөгийн ажил батлагдснаас 10 төрлийн 202192,9 мянган төгрөгийн ажил хэрэгжсэн байна.

¹⁷ Энэ журмын 2.1, 2.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглох

Аймгийн Аудитын газраас 2014 онд “Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт”-нд хийсэн нийцлийн аудитаар тус сумын 2013 оны ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-аас хэрэгжүүлэхээр суманд эрх нь шилжиж ирсэн Дуулга хороололд 2 км цахилгааны шугам барих ажлын үе шатны санхүүжилтийг гэрээнд зааснаас 8,000.0 мянган төгрөгөөр илүү санхүүжүүлсэн .
- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 10,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Рашаантын Хөтөлийн замын тохижилт, засварын ажил” нь гэрээний хугацаанд дуусаагүй, хэзээ эцэслэх нь тодорхойгүй байжээ.

Албан шаардлагын биелэлтийг 2014 оны 12 сард 1/287 тоотоор ирүүлсэн бөгөөд эрсдлийн аудитын явцад газар дээр нь очиж үзэхэд Дуулга хорооллын цахилгааны шугамын ажил болон Рашаантын Хөтөлийн замын тохижилт, засварын ажил дуусч комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байлаа.

Тус сумын ОНХС-д 2014 онд 297200,0 мянган төгрөг батлагдснаас 180600,0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ОНХС-аас хуваарилж, олгосон байна. Тайлант онд 11 төрлийн 297180,2 мянган төгрөгийн ажил батлагдснаас 10 төрлийн 223500,0 мянган төгрөгийн ажил хэрэгжсэн байна.

2015 оны 5-р сард хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын байдал” сэдэвт нийцлийн аудитаар 2014 оны ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Хушаат сумын “Сургууль, эмнэлгийн цэвэр, бохир усны шугамын засвар”-ын ажлын гүйцэтгэгч “Мөнгөн-Өргөө” ХХК-д гэрээний дүнгээс 600,0 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон,
- Хушаат сумын “Баг бүрт хүүхэд залуучуудын тоглоомын талбай байгуулах” ажлын гүйцэтгэгч “Хөшөө чулуу” ХХК-д тендер шалгаруулалтын дүнд үүссэн хэмнэлтийн 380,0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчлүүдэд нөхөн төлөх төлбөрийн акт тогтоож,
- “ХАА-н дундын үйлчилгээний төвд техник худалдан авах” 70.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй.
- “Сургууль, эмнэлгийн цэвэр, бохир усны шугамын засвар”-ын 30.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг улсын комиссын актаар хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон зэрэг нийт 100.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Эрсдэлийн аудитын явцад акт, албан шаардлагын биелэлттэй танилцахад:

Гэрээний дүнгээс илүү шилжүүлсэн 980,0 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулаагүй, сургууль, эмнэлгийн цэвэр, бохир усны шугамын засварын ажил гүйцэтгэх гэрээг 2015 оны 04-р сарын 1-н хүртэл сунгасан боловч, гүйцэтгэгч болох “Мөнгөн өргөө” ХХК нь өнөөг хүртэл бүрэн ашиглалтад оруулаагүй байна. Энэ талаар Засаг даргын орлогч Б.Атартулгаас тодруулахад “Гүйцэтгэгч “Мөнгөн өргөө” ХХК болон

хяналт тавьсан “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-т албан бичиг өгсөн боловч хариу ирүүлээгүй байна” гэсэн тайлбарыг өгч байлаа.

Иймээс цаашид дээрх 1000,0 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, санхүүжилтийг бүрэн олгосон гэрээт ажлыг гүйцэтгүүлэн, ашиглалтад хүлээн авах шаардлагатай байна. Эдгээр зөрчил нь төлбөр, санхүүжилтийг шилжүүлж буй төрийн албаны ажилтнуудын ажлын хариуцлагаас шалтгаалсан тул аж ахуйн нэгжүүдээс төлбөрийг нөхөн төлүүлээгүй тохиолдолд шилжүүлэг хийсэн албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж, тэдэнд хариуцлага тооцох нь зүйтэй юм.

СХС-ийн төлөвлөлт, зарцуулалт:

2013 онд аймаг хөгжүүлэх сангийн данснаас өмнөх оны санхүүжилт болох 50000,0 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2013 оны санхүүжилт 50000,0 мянган төгрөг, эргэн төлөлтөөс 13000,0 мянган төгрөг зэрэг нийт 113000,0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдсэн байна. Тайлант онд төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Засаг даргын захирамжаар 24 иргэнд 500,0-12000,0 мянга хүртэл хэмжээтэй нийт 113000,0 мянган төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатай, жилийн 1.5 хувийн хүүтэй олгожээ.

2014 онд хөдөлмөрийн хэлтсээс 8000,0 мянган төгрөгийн санхүүжилт, зээлийн эргэн төлөлтөөс 20000,0 мянган төгрөг зэрэг нийт 28000,0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, тайлант онд төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэж, Засаг даргын захирамжаар 4 иргэнд 2000,0-14000,0 мянга хүртэл хэмжээтэй нийт 27000,0 мянган төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатай, жилийн 1.5 хувийн хүүтэй олгожээ.

Хушаат сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 01-р сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор СХС-ийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих ажлын хэсгийн шалгалтын удирдамж чиглэлийг баталжээ. Энэ удирдамжийн дагуу ИТХ-ын Тэргүүлэгчдийн 03-р сарын 28-ны өдрийн 16 тоот тогтоолоор шалгалтын дүнг хэлэлцсэн байна.

2014 онд “Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт”-нд хийсэн нийцлийн аудитаар аймгийн Аудитын газраас “4 зээлдэгчийн зориулалт бусаар зарцуулсан 11000,0 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 26365,7 мянган төгрөг зэрэг нийт 37365,7 мянган төгрөг”-ийн зөрчилд албан шаардлага өгсөн. Аудитын явцад албан шаардлагын биелэлттэй танилцахад:

Зөрчлийг арилгах төлөвлөгөөг гарган сумын Засаг даргаар баталгаажуулан ажилласан бөгөөд хяналтын зөвлөлтэй хамтран 2 удаа, төсөл сонгон шалгаруулах зөвлөлтэй хамтран 3 удаа нийт 5 удаа хяналт шалгалтаар явж, хугацаа хэтэрсэн бүх зээлдэгч нарт зээл төлүүлэх албан шаардлагыг хүргүүлж ажилласан байна.

- Үүнээс хугацаа хэтэрсэн зээлдэгчдийг сум дундын 20-р шүүх дэх эвлэрүүлэн зуучлах албанд өгч 4879,2 мянган төгрөгийг барагдуулсан бөгөөд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 21486,5 мянган төгрөг болсон байлаа.

- Зориулалт бусаар зарцуулсан 4 зээлдэгчийн 11000,0 мянган төгрөгийг төлж барагдуулахаас 3 зээлдэгчийн 10485,5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Цаашид хугацаа хэтэрсэн зээлийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч, гэрээний дагуу барьцаат хөрөнгийг борлуулан санг хохиролгүй болгох шаардлагатай байна.

БҮЛЭГ 2.Хөрөнгийн худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэл

2.1. Худалдан авалтыг хуулийн дагуу гүйцэтгэсэн эсэх

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1, 3Г-ын 2013 оны 68-р тогтоолоор батлагдсан “ТБОНӨХБАҮ-г худалдан авахад баримтлах босго үнэ”-ийн 2¹⁸ дахь заалтыг зөрчиж:

- ЗДТГ нь 2013 онд 19354,9 мянган төгрөгийн, 2014 онд 14811,9 мянган төгрөгийн
- ЕБС нь 2013 онд 27494,7 мянган төгрөгийн, 2014 онд 24857,8 мянган төгрөгийн
- Соёлын төв нь 2013 онд 18397,3 мянган төгрөгийн, 2014 онд 17764,4 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг гүйцэтгэхдээ гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүй байна.

ЕБС нь тайлант онуудад үдийн цай болон хүүхдийн хоолны материалыг хувь хүн болон аж ахуйн нэгжээс худалдан авсан боловч ямар нэгэн гэрээ хийлгүйгээр шууд худалдан авалтыг гүйцэтгэж ирсэн байна.

Цаашид худалдан авалтыг МУ-ын ТБОНӨХБАҮ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэх шаардлагатай байна.

2.2. Хөрөнгийн орлого зарлагыг үнэн зөв бүртгэсэн эсэх

ЭМТ нь 2013 онд төсвийн санхүүжилтээр 235,0 мянган төгрөгийн ширээ худалдан авч, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 39882,5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий моорог, граж, эргэлтийн эмийн сангийн барилгыг, 2014 онд төсвийн санхүүжилтээр 210,0 мянган төгрөгийн сандал худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 13000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ЭМТ-ийн цэвэр, бохир усны шугамын засварын ажлыг капиталжуулан бүртгэсэн байна.

Соёлын төв нь 2014 онд ССАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар 2647,7 мянган төгрөгийн үнэ бүхий номын сангийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй шилжүүлснийг бүртгэлд үнэн зөв тусгасан байна.

¹⁸ ТБОНӨХБАҮ худалдан авахад баримтлах доод үнэ: бараа 10000,0 мянган төгрөг

ЕБС нь 2014 онд Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар 39954,6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 7693,1 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл нийлүүлэгдсэнийг бүртгэлд тусгасан байна. Мөн аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 14562,5 мянган төгрөгийн хүүхдийн автобусыг бүртгэлд тусган бүрэн ашиглаж байна.

МУ-ын НББ-ийн тухай хуулийн 9.1, Барилгын тухай хуулийн 21.2¹⁹ дэх заалтуудыг зөрчиж:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 300000,0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий цэцэрлэгийн барилга барьж 2010 оны 1-р сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Гэтэл шинээр баригдсан барилгыг улсын комиссын актаар хүлээж аваагүй, шинэ барилгатай холбоотой баримт, материал архивлагдаж хадгалагдаагүйгээс дуусаагүй барилгаар бүртгэгдсэн байна.
- Цэцэрлэгийн хуучин барилгыг ахуй үйлчилгээний зориулалтаар ашиглахаар орон нутгийн удирдлагаас шийдвэрлэсэн боловч сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд шилжүүлэн бүртгээгүй байна. Мөн 2013 онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 35463,0 мянган төгрөгийн засвар хийгдсэн байхад цэцэрлэгийн барилга байгууламжинд капиталжуулан бүртгэсэн байлаа.
- ЗДТГ нь үндсэн хөрөнгийн тооллогыг зургаар баталгаажуулан сайн хийсэн боловч 7049,4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 274,4 мянган төгрөгийн программ хангамж, 507,1 мянган төгрөгийн хангамжийн материалыг тавилга эд хогшилд бүртгэсэн байна.

Иймээс цаашид нэгэнт ашиглалтад орж, үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэгийн барилгыг үндсэн хөрөнгөд, хуучин барилгыг сумын ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд бүртгэж залруулах нь зүйтэй юм.

Тус сумын төр төсвийн байгууллагууд нь нүүрсний худалдан авалтыг гүйцэтгэхдээ гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүй, үндсэн хөрөнгийг УСНББОУС-ын дагуу ангилж бүртгээгүй байна.

БҮЛЭГ 3. Татварын орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

3.1. Татварын орлогыг бодитой төлөвлөсөн эсэх

3.2. Татварын орлогоо бүрэн төвлөрүүлсэн эсэх

¹⁹ Хөрөнгө оруулагч, захиалагч нь ашиглалтанд оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын гүйцэтгэлийн акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын чанар, явцад зохиогч болон мэргэжлийн хяналт гүйцэтгэгчийн дүгнэлт, ашиглалтанд хүлээлгэн өгсөн баримт бичгийг тухайн барилга байгууламжийг хүлээлгэн өгснөөс хойш 1 сарын дотор архивт шилжүүлнэ.

Тайлант онуудын төсвийн орлогын батлагдсан төсвийг, төсвийн гүйцэтгэлтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 4 /мянган төгрөгөөр/

	ОН	АНГИЛАЛ	ТӨСВИЙН ТӨСӨЛ	БАТЛАГДСАН ТӨСӨВ	ТОДОТГОСОН ТӨСӨВ	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ
Төсвийн орлого	2013 он	Татварын орлого	5008.0	20084.0	22284,0	16082,3	-4001,7
		Татварын бус орлого	2500.0	4900.0	8195,0	12420,1	7520,1
	2014 он	Татварын орлого		17839.0	30269.8	29497.9	11659.0
		Татварын бус орлого		8560.0	16841.2	15383.6	6824.0
Нийт дүн	2013 он	Нийт орлого	7508.0	24984.0	30479,0	28502,5	3518,5
	2014 он	Нийт орлого		26399.0	47111.0	44881.5	18483.0

2013 онд сумын төсвийн орлогыг 30479,0 мянган төгрөгөөр тодотгон төлөвлөснөөс 28502,5 мянган төгрөгийн буюу 94,0 хувийн гүйцэтгэлтэй, 2014 онд 47111,0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 44881.5 мянган төгрөгийн буюу 95,0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

2013 онд үйл ажиллагааны орлого 7000,0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 285,0 мянган төгрөгийн, 2014 онд 4648,1 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 1070,4 мянган төгрөгийн, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 2013 онд 5000,0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 285,0 мянган төгрөгийн, 2014 онд 1000,0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 89,5 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь татварын орлогын төлөвлөгөө тасрахад голлон нөлөөлжээ.

Татварын орлогын төлөвлөлтийн талаар сумын Төрийн сангийн төлөөлөгч О.Цогбаяраас тодруулахад *"Үйл ажиллагааны орлогын албан татварыг гүйцэтгэлийг харгалзахгүйгээр өндөр дүнгээр төлөвлөж өгснөөс, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл 2012 онд өндөр гарсан тул дараагийн жилүүдэд их дүнгээр төлөвлөснөөс шалтгаалсан"* гэсэн тайлбарыг өгсөн.

Орон нутгийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

- ❖ 2014 оны төсвийн төслийг хуулийн хугацаанд боловсруулж, хүргүүлээгүй нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 66.1.2 *"Сум, дүүргийн Засаг дарга нь орон нутаг дахь төсвийн байгууллага, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төсөл, гүйцэтгэл, сар, улирлын мэдээ, санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх"* гэсэн заалтыг зөрчиж байна.
- ❖ Хадлангийн газрын төлбөрийн 356,3 мянган төгрөгийг сумын татварын орлогын дансанд төвлөрүүлэн зарцуулсан байгаа нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 23-р

зүйлийн аймгийн татварын орлого нь 6.2 “газрын төлбөр” ... орлогоос бүрдэнэ гэсэн заалтыг зөрчсөн байна.

- ❖ Тус сумын ЗДТГ-ын байранд Хаан банк байрлаж сарын 130,0 мянган төгрөг буюу жилийн 1560,0 мянган төгрөгийн түрээсийн төлбөр, 2014 оны 4-р сарын 1-ээс Соёлын төвийн байранд Төрийн банк байрлан сарын 150,0 мянга буюу жилд 1350,0 мянган төгрөгийн түрээсийн төлбөр төлсөн байна. Энэ нь өөрийн орлогыг бүрдүүлж байгаа сайн талтай боловч Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.1²⁰ дахь заалттай зөрчилдөж байна.

Тус сум нь төсвийн төслийг холбогдох журмын дагуу боловсруулан хүргүүлээгүй, хадлангийн газрын төлбөрийг аймгийн татварын орлогод бус сумын татварын орлогод төвлөрүүлэн зарцуулсан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хушаат сумын төрийн сангийн хяналтын үйл ажиллагаа хангалтгүйгээс зохих зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд болон эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулах, тогтмол зардлын төлбөрийг бэлнээр гарган зориулалт бусаар зарцуулах, гэрээний дүнгээс илүү санхүүжилт олгох зэрэг зөрчлүүд нийтлэг байдлаар оршиж байна.

1. Зардлын бүлэг хооронд болон эдийн засгийн ангилал хооронд зохих зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулсан боловч бодитоор тайлагнаагүй байна.
2. Тогтмол зардлын санхүүжилтийг бэлнээр гарган зориулалтын бусаар зарцуулсан байна.
3. Үр дүнгийн гэрээний урамшуулал, цалингийн нэмэгдлийг давхардуулан болон илүү олгосон байна.
4. Цалингийн урьдчилгааг буцаан суутгаагүй байна.
5. ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилтийг гэрээний дүнгээс илүү шилжүүлсэн байна.
6. Сум хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн өрийг барагдуулах ажил хангалтгүй байна.
7. Төсвийн төслийг холбогдох журмын дагуу боловсруулж, архивын нэгж болгон хадгалаагүй байна.
8. Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг журмын дагуу зарцуулаагүй байна.

²⁰ Төрийн байгууллагын байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Эрсдэлийн аудитаар дараах зөрчил илэрч акт, албан шаардлага бичигдлээ. Үүнд:

Акт:

Баг:

- ✓ 2-р багийн Засаг дарга Г.Батдоржид цалингийн урьдчилгаа олгоод буцаан суутгаагүй, санхүүгийн тайланд авлага үүсгээгүй 60,0 мянган төгрөг,

ЕБСургууль:

- ✓ Багш, ажиллагсдаас цалингийн урьдчилгаа дутуу суутгасан 500,0 мянган төгрөг,
- ✓ Нягтлан бодогч Б.Номинд ээлжийн амралтын цалинг давхардуулж олгосон 433,6 мянган төгрөг,
- ✓ 2014 онд сургалтын менежер Г.Оюунцогзолмаагийн цалин дээр тушаал шийдвэргүйгээр болон үндэслэлгүй олгосон нэмэгдэл 290,0 мянган төгрөг,
- ✓ Сургуулийн захирал Л.Оюунд ур чадварын нэмэгдлийг тогтоосон хэмжээнээс илүү олгосон 289,0 мянган төгрөг ,

Албан шаардлага:

ЗДТГ :

- ✓ Төрийн захиргааны албан хаагчийн тарифаар тооцож, буудлын баримтгүйгээр олгосон томилолтын зардал 90,0 мянган төгрөг,
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 1360.0 мянган төгрөг /СТА-аар албан шаардлага өгөгдсөн /
- ✓ Үндсэн хөрөнгийг буруу ангилж бүртгэсэн 7830,9 мянган төгрөг,
- ✓ Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 531,6 мянган төгрөг,
- ✓ Босго үнээс давсан нүүрсний худалдан авалтын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүй 2013 онд 19354,9 мянган төгрөг, 2014 онд 14811,9 мянган төгрөг,
- ✓ Хадлангийн газрын төлбөрийг сумын татварын орлогын дансанд төвлөрүүлэн зарцуулсан 356,3 мянган төгрөг,

Эрүүл мэндийн төв:

- ✓ Сувилагч нарт тушаал шийдвэргүйгээр олгосон нэмэгдэл цалин 2013 онд 417,8 мянган төгрөг, 2014 онд 320,0 мянган төгрөг,
- ✓ Их эмч А.Сарантуяад ажил хавсарсны нэмэгдлийг эрхлэгчийн цалингийн шатлалаас тооцож олгосон 475,2 мянган төгрөг,
- ✓ Улирал бүр олгодог үр дүнгийн урамшуулал цалинтай давхардуулан сувилагч нарт олгосон 400,0 мянган төгрөг,
- ✓ Зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 2382,6 мянган төгрөг, /СТА-аар албан шаардлага өгөгдсөн/

ЕБСургууль:

- ✓ Босго үнээс давсан нүүрсний худалдан авалтын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүй 2013 онд 27494,7 мянган төгрөг, 2014 онд 24857,8 мянган төгрөг,
- ✓ Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 2013 онд 875,3 мянган төгрөг, 2014 онд 456,8 мянган төгрөг ,
- ✓ Томилолтын хуудасгүйгээр олгосон томилолтын зардал 48,0 мянган төгрөг

Цэцэрлэг :

- ✓ 2013 онд тушаал шийдвэргүйгээр цалингийн
- ✓ нэмэгдэл олгосон 2703,9 мянган төгрөг,
- ✓ Хүүхдийн хоолны зардлын нормативыг хэтрүүлэн зарцуулсан 427,0 мянган төгрөг,
- ✓ Зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулаад гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 1127,0 мянган төгрөг,
- ✓ Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 2013 онд 1213,2 мянган төгрөг, 2014 онд 400,1 мянган төгрөг

Соёлын төв:

- ✓ Нүүрсний худалдан авалтыг гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүй 2013 онд 18397,3 мянган төгрөг, 2014 онд 17764,4 мянган төгрөг,
- ✓ Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 893,2 мянган төгрөг

Хушаат сумын төр төсвийн байгууллагуудад нийт 142819,9 мянган төгрөгийн төлбөр, зөрчил илэрч 1572,6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 141247,3 мянган төгрөгийн албан шаардлага бичигдлээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

1. ЗАСАГ ДАРГА Г.ГАЛБАДРАХ-д

- ✓ Төсвийг зохистой удирдаж, өглөг, авлага үүсгэхгүй ажиллах
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгийг журмын дагуу зарцуулах
- ✓ Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хэрэгжилт, үр дүнд байнгын хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах арга хэмжээ авах.
- ✓ Сургууль, эмнэлгийн цэвэр, бохир усны шугамын засварын ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулах, гэрээт ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөөгүй байхад санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох.
- ✓ 2014 оны ОНХС-ийн хөрөнгийг гүйцэтгэгч байгууллагад гэрээний дүнгээс илүү шилжүүлсэн 980,0 мянган төгрөгийг нэн даруй барагдуулах.

2. ТӨРИЙН САНГИЙН ТӨЛӨӨЛӨГЧ О.ЦОГБАЯР-т

- ✓ Харилцагч байгууллагуудтай тухай бүр тооцоо нийлж, үлдэгдлийг актаар баталгаажуулах шаардлага тавьж, өр авлага үүсгэхгүй ажиллах
- ✓ Зайлшгүй тохиолдолд зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахад журмын дагуу шаардлага тавьж, гүйцэтгэлийг бодитой тайлагнуулах
- ✓ Төрийн сангийн хяналтын чиг үүргийг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэх, төсвийн байгууллагууд дээр оршиж буй их хэмжээний зөрчлийг арилгах.
- ✓ Тогтмол зардлын санхүүжилтийг бэлнээр гаргаж буй гүйлгээг баталж, гүйцэтгэхгүй байх.

3. ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ц.АЛИМЦЭЦЭГ, НЯГТЛАН БОДОГЧ Б.НОМИН НАРТ

- ✓ Тус байгууллагын бүртгэлд байгаа ахуй үйлчилгээний барилгыг сумын ЗДТГ-ын балансанд шилжүүлэх
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010 онд ашиглалтанд орсон барилгын улсын комиссын акт болон холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн авч, дуусаагүй барилгаас барилга байгууламжинд шилжүүлэн бүртгэх

4. БАЙГУУЛЛАГУУДЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР, НЯГТЛАН БОДОГЧ НАРТ

- ✓ Төсвийн төслийг холбогдох журмын дагуу боловсруулж, архивийн нэгж болгон хадгалах
- ✓ Батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах.
- ✓ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнах
- ✓ Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх, зайлшгүй тохиолдолд эрх бүхий байгууллагаас журмын дагуу зөвшөөрөл авах
- ✓ Цалингийн нэмэгдлийг хууль, тогтоомжийн дагуу олгож байх
- ✓ Түлш халаалтын зардалд зарцуулалтын норм тогтоож, хяналтын тогтолцоог сайжруулах;
- ✓ Хүүхдийн хоолны нормативт зардлыг мөрдөх.
- ✓ Тогтмол зардлын гүйлгээг бэлнээр гүйцэтгэхгүй байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АУДИТОР

Ц.ОТГОНБАЯР

ШИНЖЭЭЧ

С.БААСАНСҮРЭН

Э.ЭРДЭНЭЗУЛ

А.ДАШБАТ